



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын ┐
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Завхан аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 3,297,070.00 (гурван сая хоёр зуун ерэн долоон мянга далан) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоосугай.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга хошууч генерал Г.Ариунбуян, Завхан аймгийн Онцгой байдлын газрын дарга хурандаа Ө.Болд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4 Арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132004667
7-1-nuraleaан.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн
94..... дугаар тогтоолын хавсралт



**ЗАВХАН АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР
ХУДАЛДАХ АВТОМАШИН**

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	ТӨБЗГ-ын 2022 оны 72 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
1	ЗИЛ-131 автомашин, улсын дугаар 62-91 ЗАА	1978	3,297,070.00	1,000,000.00	700,000.00
Нийт дүн			3,297,070.00 (гурван сая хоёр зуун ерэн долоон мянга далан төгрөг)	1,000,000.00 (нэг сая)	700,000.00 (долоон зуун мянга)